



УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ.  
ЧАНДМАНЬ НАЛАЙХ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Д.ГАНЗОРИГ  
2024 оны 04 дүгээр сарын 29 өдөр

## НАЛАЙХ ДҮҮРГИЙН I, VII ХОРООНЫ ҮЕРИЙН ЭРСДЭЛД

### ӨРТӨЖ БУЙ УС ТҮГЭЭХ БАЙР №26, №05 ШИНЭЭР

#### БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгчийн газраас Япон улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Улаанбаатар хотын үерийн эрсдэлтэй бүсэд нийгмийн эрүүл мэндийг хамгаалж ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Налайх дүүргийн үерийн усны эрсдэлийн үед түр цугларах байрын ойролцоо байрлах үерийн усанд өртөж буй ус түгээх байруудыг буулгаж шинээр барих ажил.

**Байршил:** Налайх дүүргийн I-хороо уурхайчины-15 байрлах ус түгээх байр №05, VII-дугаар хорооны Өвөр шандын-16 гудамжинд байрлах ус түгээх байр №26

**Ажлын цар хүрээ:** Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээнд байгалийн хүчин зүйлээс шалтгаалан хүндрэл учирч буй хуучин зөөврийн хоёр ус түгээх байрыг буулгаж, шинээр үер усны хамгаалалттай, гадна тохижилт хашаа хайс бүхий ухаалаг төхөөрөмжтэй 24/7 цагийн үйлчилгээтэй иж бүрэн худгийг шинээр барих.

**Зураг төсөв:** Сонгино хайрхан дүүргийн №947-р худгийн жишиг зураг “Блю мандал арт” ХХК-ны 2024 оны ЕГ Шифр: БМА-07/2024, Төсвийн дугаар: БМА-011/24 дагуу хийж гүйцэтгэнэ.

#### Ажлын тоо хэмжээ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>Хуучин худгийн барилга буулгах ажил</b>			
1	Хуучин барилгын тоосгон хана задалж буулгаж	м3	26,6
2	Барилгын бетон суурь задалж буулгах	м3	4,4
3	Барилгын хог хаягдал ялгаж овоолох авто машинд эксковатораар ачих	м3	40,3
<b>Газар шороо суурийн ажил.</b>			
4	2м хүртэл өргөн 2м хүртэл гүн бэхэлгээт шуудууг 2-р зэргийн хөрсөнд шараар ухах	м3	3,22
5	Бетон шахах шахуургаар төмөр бетон нил суурь арматурчилж цутгах	м3	7,45
<b>Металл карказан барилгын угсралтын ажил</b>			
6	Метал карказ хийцийн бэлдэц бэлтгэх	ш	1
7	Ханын төмөр карказ бэлдэц гагнаж бэхлэх	тн	0,827
8	Дээвэр болон саравчны төмөр карказ бэлдэц гагнаж бэхлэх	тн	0,263
9	Дотор тусгаарлах ханыг карказ бэлдэц гагнаж бэхлэх	тн	0,325
10	Ус зайлуулах хоолой далд угсрах	тн	0,1
11	10 см зузаан эрдэс хөвөн хавтангаар дулаалга хананд хийх	м2	59,36
12	10 см зузаан эрдэс хөвөн хавтангаар дулаалга	м2	27,09

	таазанд хийх		
13	Гадна ханарпетны хамт металл хавтангаар өнгөлөх	м2	75,88
14	5 см ховилтой чанартай зузаан цайрдсан төмрөөр дээвэр хийх	м2	33,81
15	Гонх болон ус түгээх өрөөний дотор хана металл хавтангаар хийх	м2	24,64
16	Ус хадгалах болон галалгааны өрөөний ханыг тосон будгаар эмжээр татаж будах	м2	59,36
17	Гадна хананд дулаалгатай төмөр 2м2 хүртэл хаалга суулгах	ш	1
18	Дотор хананд хаалга суулгах	м2	5,5
19	Хаалганд цоож хэрэглэл суулгах	ш	4
20	Толин тусгалтай цэнхэр шилтэй вакум цонх угсрах	м2	2,1
21	Цонхны зай завсарыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	9,6
<b>Ухаалаг худаг ус хангамжийн ажил</b>			
22	Худгийн дотор сантехникийн холболт хийх ф20 PPR	ш	12
23	Худгийн дотор сантехникийн хоолой угсрах ф20 PPR	м	12
24	Цахилгаан хаалт Autosigma d=15 мм байрлуулах	ш	1
25	Импульсан тоолуур ф 15 ВСГ угсрах	ш	1
26	Цахилгаан автомат вакум насос суурилуулах ф-25 0,5-1 квт	ш	1
27	Автомат мэдрэгчтэй хөвөгч суурилуулах	ш	1
28	9 тонны багтаамжтай ус хадгалах сав суурилуулах	ш	1
<b>Ухаалаг худгийн төхөөрмжийн угсралт</b>			
29	Ухаалаг худгийн ерөнхий удирдлагын самбар угсрах	ш	1
30	Ухаалаг худгийн карт таниулах	ш	200
31	Хэрэглэгчийн самбар угсрах BEMP LCD 15" MIFARE	ш	1
32	Галын болон температур дохиоллын систем суурилуулах Photoelectric system	ш	1
33	Цахилгаан халаагуур радиатор угсрах 2300вт хүртэл	ш	3
<b>Дотор цахилгааны ажил</b>			
34	Гадна гэрэлтүүлэг, цахилгааны удирдах самбар угсрах	ш	1
35	Оролтын самбар угсрах ОС-1	ш	1
36	Хамгаалагдсан ханын LED гэрэлтүүлэгч угсрах	ш	3
37	Нэг даралттай унтраалга тавих	ш	1
38	Далд угсрах хоёрлосон розетка тавих	ш	6
39	2,5 кв мм2 зэс голчтой ПВ утас угсрах	м	28
<b>Ажиглалтын дуран сүлжээний ажил</b>			
40	4 сувгийн ажиглалтын IP NVR төхөөрмж угсрах	ш	1
41	Хэрэглэгчийн видео төхөөрөмжийг дотор хананд угсрах МНК IP 5MP	ш	3
42	Хэрэглэгчийн видео төхөөрөмжийг гадна шонд	ш	2

	угсрах МНК IP 5MP		
43	Кабель утасыг хоолойд сүвлэх	100м	0,7
44	Утасгүй интернет урсгалын төхөөрөмж угсрах	ш	1
<b>Гадна тохижилтын ажил</b>			
45	Төмөр сараалжин хашааны шон суулгах / өндөр 1,5 метрээс их байх /	ш	16
46	Төмөр сараалжин хашааны хайс хийж угсрах / өндөр 1,5м их урт нь 26 метр/	м2	44
47	Гадна гэрэлтүүлэгч угсрах /лед-150вт нар салхины энергиэр ажилладаг, цахилгаанаар хосолсон /	ш	2
64	Шавардлагын цементэн зуурмаг м1:3	м3	0,188
66	Бетон зуурмаг м-100	м3	0,612
67	Бетон зуурмаг м-75	м3	2,448

### **Зураг Төсөл Зохиогч:**

- Барига хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зохиогчийн хяналт тавих дүрэм”-ээр хүлээсэн эрхийг эдэлж, үүргийг дагаж мөрдөнө.

### **Захиалагч Байгууллагын зүгээс тавих ерөнхий шаардлага:**

- Барилга хот байгуулалтын яамнаас олгосон доорхи тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:

**БХБ-н сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага:**

**БА-6,1.** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

**БА-6,2.** Барилга байгууламжын дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

**БА-6,3.** Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

**БА-6,4.** Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

**БА-7,1.** Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

- Сүүлийн 5 жилд ОУБ-ын төсөл хөтөлбөрөөр ус хангамжийн чиглэлийн ижил төстэй ажил 3-аас доошгүй хийж гүйцэтгэсэн байх.

➤ Мэргэжилийн боловсон хүчинээр бүрэн хангагдсан байх. Үүнд: Сантехникийн инженер /халаалт агаар сэлгэлтийн инженер/, Барилгын инженер, Программ хангамжийн инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан г.м

➤ Ус хангамжийн чиглэлээр барилгын ажил гүйцэтгэх Тусгай зөвшөөрөлтэй ААН байх

➤ Ухаалаг ус түгээх байр барьж ашиглалтанд хүлээлгэн өгч байсан ажлын дадлага туршлагатай байх

➤ Худгийн барилгын ажлыг "БЛЮ МАНДАЛ АРТ" ХХК-ны 2024 оны зөөврийн ус түгээх байрны нэг маягийн зургийн дагуу хийж гүйцэтгэх.

➤ Ус нөөцийн сав FRP болон JRP хүчиллэг нэхдэст зориулалтын сав суурилуулах, савны хэмжээ 9,0 тонн байх

➤ **Ухаалаг төхөөрөмж суурилуулах.**

А. Мэдээллийн нэгдсэн сан. Бүх ухаалаг худгуудыг удирдлагаар хангах, гуравдагч системүүд холбогдох, худгуудаас мэдээлэл цуглуулах, хуваарилах зэргийг хийж гүйцэтгэдэг байх

Б. Шинэ төхөөрөмж нь одоо ашиглаж буй бүх худгуудтай картын нэгтгэлийг хийж өгөх шаардлагатай. Ашиглахад хялбар байх үүднээс диспетчерт усаа авч буй агшнийг харуулах, зөөврийн худгуудын усаа дууссан мэдээллийг диспетчер харах боломж олгосон байх. Online карт цэнэглэлтийн хурд 1 минутаас хэтрэхгүй байх. Ашиглагч байгууллага болон хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байх.

В. Одоо ашиглаж буй ухаалаг ус түгээх системийн мэдээллийн сантай уялдаж холбогдож ажиллах боломжийг бүрдүүлсэн байх. Өөрөөр хэлбэл хэрэглэгч нэг картаар аль ч ухаалаг худгаас саадгүй ус авах боломжийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Г. Карт. Дахин давтагдахгүй байх, ашиглаж буй серверт кодлогдож танигдах бөгөөд өөр төрлийн ямар ч картаар усаа авах боломжгүйгээр хамгаалагдсан байх. Картыг хэрэглэгч онлайн орчинд төвөггүй цэнэглэдэг байх.

Д. Усны тоолуур. Механик болон электрон хосолсон ба нарийвчлал 1литр. Усны тоолуур нь Монгол улсад ашиглах Стандартчилал хэмжил зүйн газраар баталгаажсан гэрчилгээтэй байх шаардлагатай.

Е. Удирдлагын товчлуур. Гаднаас хэрэглэгч шууд удирдах боломжтой, эвдрэл байхгүй, хэрэглэхэд хялбар, цельсийн -50с-аас +45с градуст хэвийн ажилладаг байх. Эвдрэл гарсан үед өртөг хямд сольж тавихад хялбар байх.

Ё. Хэрэглэгчийн дэлгэц. Картын дугаар болон хэрэглэгчийн овог нэр, дансны үлдэгдэл, усны зарцуулалт шууд харагддаг байх. Нарны тусгалын нөлөөгөөр гялбахаас хамгаалагдсан байх.

➤ Хот суурин газрын ундны усны ус түгээх байрны үйлчилгээ түүнд тавих ерөнхий шаардлага MNS5775:2014 стандартын 8.4-д заасны дагуу эрүүл ахуйн бүст хамгаалалтын хашаа, хайс барих. / хэмжээ 1,5 метрийн өндөртэй, өнгө үзэмж сайтай байх/

➤ Ус түгээх байрны гадна хаалга 9 см дулаалгатай төмөр листэн хаалга, дотор тусгаарлах өрөөнүүдийн хаалга ус чийгэнд тэсвэртэй бактерийн хамгаалалтай будагтай модон хаалга байх

➤ Ус нөөцийн сав байрлах өрөөний тааз ус чийг нэвтрэхгүй, тоос шороо орохгүй битүү зориулалтын угсардаг төмөр байх.

➤ Хэрэглэгчийн ус авах талбайд өнгөт хавтан суулгах эсвэл бетондох. Хэмжээ 4x3 м нийт 12 м2 талбайтай зузаан нь 10см –ээс багагүй байх.

**Захиалагчийн хяналт:**

- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаа
- Материалын чанар
- Барилгын ажлын явцад гарах ажлын тоо хэмжээтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтран шийдвэрлэх

**Гүйцэтгэх байгууллага:**

- Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
- Ажлын талбай дээр ажил эхлэхээс өмнө ажил эхэлж байгааг мэдэгдэж, анхааруулга тэмдэг тавьж оршин суугч, иргэдийн аюулгүй байдал, гэнэтийн аваарь осол гаргахгүй байхаар ажлыг явуулна.
- Ажлын талбайд журнал байнга байлгаж, хяналтын ажилтануудын өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.
- Ажил гүйцэтгэх явцдаа байнга фото зургаар баталгаажуулан далд ажлын акт үйлдэнэ.
- Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээж, хэвийн байдалд оруулна.
- Ажил гүйцэтгэх талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж ажиллана.
- Байгалийн гэнэтийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлөөс сэргийлэн даатгалд хамрагдаж, аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Эдгээр арга хэмжээг авалгүй гэнэтийн гамшигт өртөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зөрчил гаргавал хор хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.
- Ажлын явцад үүссэн хог хаягдлыг барилгын ойр орчмоос зайлуулан дүүргийн хогийн цэгт хаях ажлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.
- Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

ХЯНАСАН: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



А.УУГАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН: ТӨСЛИЙН АЖИЛТАН



Н.СЭЛЭНГЭ